



USAID
FROM THE AMERICAN PEOPLE



МОНГОЛЫН ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗАСАГЛАЛ ХӨТӨЛБӨР

ЗОРИЛГО

АНУ-ын ОУХА-ийн Монголын эрчим хүчний засаглал (МЭХЗ) хөтөлбөр нь эрчим хүчний салбарын засаглалыг сайжруулах замаар Монгол Улсын эрчим хүчний салбарын аюулгүй, найдвартай, төрөлжсөн, орчин үеийн, бие даасан байдлыг дэмжих зорилготой юм. Тус хөтөлбөр нь (а) эрчим хүчний салбарын хувийн хөрөнгө оруулалтыг эрчимжүүлэх, (б) эрчим хүчний үйлдвэрлэл болон менежментийн шинэ дэвшилтэт технологийн хэрэглээг дэмжих, (в) хүндрэлтэй нөхцөлийг тэсвэрлэх чадварыг сайжруулахын тулд өрсөлдөөнд суурилсан ил тод байдлыг бий болгох хууль эрх зүй, зохицуулалтын орчныг дэмжин ажиллана.

МЭХЗ ХӨТӨЛБӨР НЬ ДАРААХ ХҮРЭЭНД ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛНА.



Цахилгаан болон дулааны эрчим хүчний системийн төлөвлөлт болон үйл ажиллагааны үр ашгийг сайжруулах

МЭХЗ нь эрчим хүчний салбарын төлөвлөлт болон үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэхэд өгөгдлийн шинжилгээг ашиглах аргачлал, мэдлэг чадварыг нэмэгдүүлнэ.



Эрчим хүчний салбарын зах зээлийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх

МЭХЗ нь эрчим хүчний салбарыг зах зээлийн зарчим руу шилжих явцыг дэмжиж, Монголын Засгийн газрын ил тод худалдан авах чадавхыг сайжруулна.



Орчин үеийн эрчим хүчний технологи нэвтрүүлэхийг дэмжих

МЭХЗ нь эрчим хүчний үр ашгийг нэмэгдүүлэн, үйлчилгээний чанарыг сайжруулж, агаарын бохирдлыг бууруулах орчин үеийн технологийг нэвтрүүлэхийг дэмжинэ.



Эрчим хүчний үр ашиг, хэрэглэгч талын менежмент

МЭХЗ нь хэрэглэгч талын менежмент болон эрчим хүчний үр ашгийг сайжруулах замаар эрчим хүчний хэрэглээг бууруулахад хувь нэмэр оруулна.



Олон нийттэй харилцах

МЭХЗ нь эрчим хүчний шилжилтийг дэмжих зорилгоор олон нийт болон бусад оролцогч талуудад зориулан мэдээллийн аян явуулна.



Монголын Эрчим Хүчний Судалгаа, Инновацийн Сан

МЭХЗ нь эрчим хүчний салбарын экосистем бий болгох, монгол байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх зорилгоор Монголын Эрчим Хүчний Судалгаа, Инновацийн Сан (МЭХСИС)-г байгуулна.



Жендэрийн эрх тэгш байдал, нийгмийн олон талт төлөөллийн оролцоог хангах

МЭХЗ нь эрчим хүчээр ханган нийлүүлэх болон хэрэглэхтэй холбоотой бүхий л хүрээнд жендэрийн эрх тэгш байдлыг хангахад хувь нэмрээ оруулна.



USAID-ИЙН ТУХАЙ

АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг USAID нь хүний амь насыг аврах, ядуурлыг бууруулах, ардчилсан засаглалыг бэхжүүлэх, улс орнуудад тусламж үзүүлж илүү ахиц дэвшил гаргахад нь чиглэсэн олон улсын хөгжил, хүмүүнлэгийн хүчин чармайлтыг удирдан чиглүүлэгч байгууллага юм. USAID нь Монгол Улсад ил тод, хариуцлагатай засаглал, зах зээлд илүү тулгуурласан, төрөлжсөн эдийн засгийг дэмжин ажиллаж байна.

АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг (USAID)/Монгол улс
Улаанбаатар дахь АНУ-ын Элчин Сайдын Яам
www.usaid.gov/mongolia

infomongolia@usaid.gov
www.facebook.com/USAIDMongolia
www.twitter.com/usaid_mongolia